

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ,  
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ

## **СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар  
2020 он

# ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН<sup>1</sup>

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

### 1.1. Асуудлын мөр чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь хүний алдар хүндийг тодорхой хүрээнд хязгаарлах замаар л хангагдах бололцоотой учир ийнхүү хязгаарлах хүрээ хязгаарыг тогтоох асуудал нийгмийн шинжлэх ухаанд ихээхэн маргаан дагуулж байдаг. Хүний нэр төртэй байх буюу нийгмийн гишүүн болж төрснийхөө хувьд хүлээн зөвшөөрөгдөх эрх, хүний үзэл бодлоо ямар нэг саадгүйгээр илэрхийлэх эрх чөлөө хоёул ардчилсан нийгмийн амин сүнс. Иймээс эрх зүйт төрийг эрхэмлэсэн ардчилсан улс орнууд эдгээр эрхийн зохистой тэнцвэрийг олсон хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгоход ихээхэн ач холбогдол өгдөг байна.

Тус хоёр эрхийн мөргөлдөөнийг тэнцвэртэй зохицуулсан байдлаас тухайн улс хэр ардчилсан гэдэг нь хэмжигддэг тул Монгол Улс уг асуудлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд нийцүүлэн зохистой уялдуулах шаардлагатай байна.

### ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ, ТҮҮНИЙГ ЗОХИСТОЙ ХЯЗГААРЛАХ АСУУДАЛ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө гэж гагцхүү худал мэдээлэл болон худал үгээр бусдын нэр төр, алдар хүндэд халдсан нөхцөлд хязгаарлагддаг, харилцаа холбооны аливаа хэрэгслээр үзэл санаа, үзэл бодлоо хэлэх эрхийг ойлгох бөгөөд хэвлэн нийтлэх эрхийг дотроо багтаана.

Хүний нэр төр, алдар хүндийг хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хооронд нь жишиж харьцуулах замаар жинлэх боломжгүй хэдий ч эрх зүйн орчин үеийн чиг хандлагаар үүнийг эрхийн зөрчилдөөн бус үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх **эрх чөлөө** болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг “**нийтийн эрх ашиг**” хоорондын тэнцвэрт байдал гэх хандлагаар авч үзэж байна.<sup>2</sup> Иймд хоёр эрх хоорондоо аль нэг нь зөрчигдөхөөс нааш хангагдах боломжгүй бус, харин уг асуудлыг тодорхой зарчимд нийцүүлэн хуульчилж, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ шүүх үүнийг баримтлах тохиолдолд эрхийн зөрчилдөөнгүйгээр зохицуулагдах боломжтой байна.

Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг зарчимтай. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ гэдэг хүссэн зүйлээ хүссэн газраа дураараа хэлж ярихыг

<sup>1</sup> Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

<sup>2</sup> Heyman, Steven. (2008). Free Speech and Human Dignity.

ойлгодоггүй. Германы сонгодог философич Г.В.Гегель “Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн өөрийн үйлдлийн хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал” гэж хэлсэн. ЧӨЛӨӨТЭЙ илэрхийлнэ гэдэг хэзээ ч юугаар ч хязгаарлагдахгүй туйлын эрх гэсэн утгыг бус энэ эрхийг гагцхүү тодорхой шалгуураар, хуульд заасан үндэслэлээр хязгаарлана, бусад тохиолдолд төр эсхүл аливаа этгээд уг эрхийг боож хаах, өөрийнхөө эрх ашгийн үүднээс хязгаарлаж болохгүй гэдэг утгыг илэрхийлнэ. Иймд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүнд багтах хэвлэн нийтлэх эрх чөлөө хуульд заасан үндэслэлээр, хатуу шалгуурт баригдан юун түрүүнд хязгаарлагддаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Хэлбэрийн хувьд хүн өөрийн үзэл санаа, бодлыг ярих, бичих, дуулах, жүжиглэх, сурталчилгаа хийх, гудамжинд орилох, ёс бус үг хэллэг хэлэх зэрэг олон янзын хэлбэрээр илэрхийлж болно. Ингэж илэрхийлж байгаа аргууд агуулга, ач холбогдлын хувьд ялгаатай байдаг учир үүнийг дагаад эрхийн ялгамжтай хамгаалалтыг шаарддаг. Жишээ нь, төрийн үйл ажиллагааг шүүмжлэх эрх нь нэг уран бүтээлчийн бүтээлийг шүүмжлэх эрхээс давуу байна. Учир нь иргэний ардчилсан нийгмийг бүрдүүлэхийн тулд төрийн эрх барих байгууллагад олон нийт үргэлж дуу хоолойгоо хүргэх, улс төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагааг чөлөөтэй шүүн хэлэлцдэг байх шаардлагатай.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бүхэлдээ дархлагдан хамгаалагдах ёстой гэвэл өрөөсгөл болно. Ямар ч хүрээ хязгааргүй үг хэлэх эрх чөлөө байх тохиолдолд худал мэдээллийг зоргоороо тараах, бусдыг элдвээр доромжилж хараах, улсын нууц задруулах, хүүхдэд садар самуун сурталчлах бүхий л үйл ажиллагаа явуулсны төлөө хууль зүйн хариуцлага хүлээлгэдэггүй байх байсан. Ийнхүү үзэл санаагаа илэрхийлж байгаа зорилго, хүрэх гэсэн үр дүнгээр нь хуулиар хамгаалагдах болон хамгаалагдах боломжгүй үзэл санааг ялгах боломжтой болно.<sup>3</sup>

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүнийг хязгаарлах нөхцлийг дараах байдлаар зохицуулжээ:

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар,

---

<sup>3</sup> van Mill, David, "Freedom of Speech", *The Stanford Encyclopedia of Philosophy* (Summer 2018 Edition), Edward N. Zalta (ed.)

бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

**a/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;**

**b/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.**

Үзэл бодлоо чөлөөтэй эдлэх эрх чөлөөг бусдын эрх, нэр төр, алдар хүндийг хамгаалах үүднээс хязгаарлах шаардлагыг тайлбарлахдаа хэд хэдэн ерөнхий зарчмыг баримтлахыг Эмнести Интернэйшнл байгууллага зөвлөмж болгон гаргасан байна. Үүнд:

- **Нарийн тодорхой байх**- хязгаарлаж байгаа үндэслэл, хязгаарлалт нь өөрөө нарийн тодорхой байх нөхцөлд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлж зөрчих нөхцөл үүсэхгүй. Жишээ нь, цахим веб хуудасны зөвхөн нэг дэд хэсэг хүний алдар хүндэд халдсан байхад веб хуудсыг бүхэлд нь хаах арга хэмжээ авах нь зохимжгүй.
- **Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалах**- улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаас эхлээд нийт хүн амын аюулгүй байдлын баталгааг хамгаалах үүднээс иргэдийн хувийн эрх, эрх чөлөөг хязгаарлах асуудал яригддаг. Гэвч үүнийг тодорхойлохдоо мөн л нарийн тодорхой үндэслэл байх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам гэх хуулиар нэг бүрчлэн тодорхойлох боломжгүй, ерөнхий өргөн агуулгатай ойлголтыг төр урдаа барьж хувь иргэний эрхийг зөрчсөн үйлдлээ халхавчаар зөвтгөдөг байж болохгүй.
- **Ёс суртахууныг хамгаалах**- үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг ганц үндэстэн угсаатны уламжлал, шашны үзэл баримтлалыг баримтлан хязгаарлаж болохгүй. Нөгөөтэйгүүр тодорхой нэг нийгмийн бүлгийг ялгаварлан гадуурхсан, тохоорхон доромжилсон үзэл санааг хязгаарлах шаардлагатай.
- **Бусдын нэр төр, алдар хүндийг хамгаалах**- Хүний нэр төр гэдэг хүн болж төрснийхөө хувьд бусдаар хүлээн зөвшөөрүүлэх, хүнлэг хүндэтгэлтэй харьцах боломжтой байхаар тодорхойлогдоно. Хүн бүр эрхэм чанартай учраас төрийн албан хаагч, улс төрийн албан тушаалтан байхаас үл хамаарч хувь хүнийхээ хувьд нэр төрөө хамгаалуулах эрхтэй. Харин алдар хүнд буюу албан тушаал, эрхэлж

буй ажил, мэргэжил, олны хүндэтгэл бишрэлийг олж авсан байдал нь хэмжигдэж, өөрчлөгдөж байдаг бөгөөд төрийн эрх бүхий болон улс төрийн албан тушаалтнууд олон нийтийн шүүмжлэл, хардлагыг хувь иргэнээс илүү тэвчдэг, хүлцэж хүлээн авдаг байх шаардлагатай. Тэднийг хувь иргэнийх нь хувьд бус албан тушаалтных нь хувьд шүүмжилж, тодорхой нэг хууль бус хэрэгт сэжиглэн олон нийтэд мэдээлэл хүргэсний төлөө шийтгэдэг эрх зүйн зохицуулалттай байх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчиж байдаг.

- **Хэвлэл мэдээллийн байгууллага ба сэтгүүлчдийг хамгаалах-** Төрийн байгууллагын гомдол, дарамтаас болж хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэлтэй байх иргэдийн эрх шууд зөрчигддөг. Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчдад их хэмжээний торгууль оногдуулах, хорих ялаар шийтгэх байдлаар төрийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрхийг зөрчих нь улс оронд дарангуйллын дэглэм тогтох үндэс суурь болно.
- **Мэдээлэгч буюу хууль бус үйлдлийг задруулагчийг хамгаалах-** Улс орнууд хүний эрх зөрчигдөж буй асуудлыг илрүүлсэн, нийтэд мэдээллэсэн, зөрчигдсэн эрхийг сэргээхийг шаардсан хүний эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй.

Монгол Улс дээрх зарчмыг баримталсан эрх зүйн зохицуулалтыг бий болгож хараахан чадаагүй. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр бусдын нэр төр, алдар хүндийг хамгаалж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа олон нийтийн зүтгэлтэн (public figure), улс төрч, төрийн албан тушаалтнуудын гомдол гаргах эрхийг нээлттэй байлгасаар байна. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрх, иргэдийн цахим орчинд бусдын нэр төр, алдар хүндийг гутааж болох ч төрийн үйл ажиллагааг шүүмжлэх боломжгүй байдал бий болгосоор байна. Эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтны албаны үйл ажиллагааг шүүмжлэх, тодорхой хэрэгт хардсан хүнд эрүүгийн хэрэг үүсгэх байдлаар айлган сүрдүүлэх, дарамтлах боломж олгосон ерөнхий зохицуулалт үйлчилж байна. Бусдын нэр төр, алдар хүндэд халдсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт хэт ерөнхий байснаар ардчиллын үнэт зүйл болсон мэдэх эрх, үг хэлэх эрх, хэвлэлийн эрх чөлөө хязгааргүйгээр хязгаарлагддаг.

Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна. Аливаа этгээдийг хувь хүнийх нь хувьд доромжилж, хүний хувьд өөрөөс нь салгашгүй, үнэлшгүй тэрхүү нэр төрийг гутаасан үйлдлийг хязгаарлах ёстой. Харин тодорхой фактад үндэслэн нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар олон нийтийн

зүтгэлтнийг хурцаар шүүмжилсэн нь үзэл бодол буюу үнэт зүйлийн шийдвэрт хамаарч хамгаалагдах ёстой байна.

## НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, ТҮҮНИЙГ ЗОХИСТОЙ ХАМГААЛАХ АСУУДАЛ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хэн ч бусдын эрх, нэр төрд халдаж болохгүй байна. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжид заасан нэр төр, алдар хүндийн ойлголтыг хууль зүйн шинжлэх ухаанд ялгамжтай тайлбарлан бичиж ирсэн нь хууль хэрэглээний зарим тодорхойгүй байдлыг үүсгэсэн байна. Иймд нэр төр, алдар хүндийг бусдын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчихгүйгээр хамгаалах зохицуулалтыг авч үзэхийн өмнө нэр томъёоны асуудлыг тодруулан авч үзье.

Нэр төр, алдар хүнд, нэр хүнд, хүний эрхэм чанар, хүний эрхэмсэг оршихуй зэрэг ойлголтуудыг бүгдийг ойролцоо утгаар ойлгож, орчуулан хэрэглэж ирсэн. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1.2-т “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” нь иргэний үндсэн үүрэгт хамаарахаар хуульчилжээ.

**Нэр төр** гэдэгт тухайн хүний албан тушаал, хөрөнгө мөнгө, авьяас чадвар, гаргасан ажлын амжилт, олны хүндэтгэлийг хүлээсэн эсэх бус хүн болж төрснийхөө хувьд бусдаар хүн гэж хүлээн зөвшөөрүүлж хүндлүүлэхийг ойлгодог. Иргэний эрх зүйд эдийн бус баялгийн нэг, бусдад шилжүүлж ба дамжуулж болшгүй төрөлх шинж, хүнээс огт салгашгүй шинжийг ойлгодог байна. Нэр төрийн агуулгыг хүний эрхэм чанар, хүний эрхэмсэг оршихуй гэж нийгмийн шинжлэх ухаанд тодотгон хэрэглэх нь бий.

**Алдар хүнд**<sup>4</sup> гэх хууль зүйн ойлголт нь хүн хөдөлмөр зүтгэл, авьяас билиг, ур чадвар, ёс суртахууны эрхэм чанараараа бусдаас буюу нийгмээс олж авч, унаж ба босч байдаг үнэлгээг илэрхийлсэн ойлголт. Өөрөөр хэлбэл, нийгмийн зүгээс бодгальд өгч буй ёс суртахууны үнэлэлт дээр нэмэгдээд хүн өөрөө өөрийгөө үнэлсэн ухагдахуун юм. Тэр ч утгаараа нэр төр, алдар хүнд нь тус бүртээ ялгамжтай хууль зүйн хамгаалалт, ялгамжтай эрхийн зохицуулалтыг шаарддаг.

Уг хоёр ойлголтыг гадаад хэлнээс булгахдаа зарим зөрүүтэй байдал бий болгосноор тэдгээрийн нарийн ялгааг гаргаж зохицуулахад хүндрэлтэй болсон юм. Хууль зүй, дотоод хэргийн яамны харъяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргасан Монгол Улсын Үндсэн хуулийн албан бус орчуулгад **нэр төр-dignity, алдар хүнд- reputation** гэж буулгасан<sup>5</sup> нь хууль зүйн ойлголтын мөн чанар, утгыг зөв илэрхийлж байна.

<sup>4</sup> Нэр хүнд гэж ярианы хэлэнд хэрэглэгдэх нь бий.

<sup>5</sup> Монгол Улсын Үндсэн хууль /Монгол, орос, англи, франц, герман, япон, хятад, солонгос хэлээр/ Хууль зүйн үндэсний хүрээлэн V хэвлэл, УБ, 2014 он, х.67

Монгол Улсын Үндсэн хууль (1992)	The Constitution of Mongolia (1992)
<p><b>Арван долдугаар зүйл.</b></p> <p>1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;</li> <li>2) хүний <b>нэр төр, алдар хүнд</b>, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;</li> <li>3) хуулиар ногдуулсан албан татвар төлөх;</li> <li>4) эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.</li> </ol>	<p><b>Article Seventeen.</b></p> <p>1. The citizens of Mongolia shall uphold justice and humanity, and shall discharge in good faith the following basic duties:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Respect and abide by the Constitution and other laws</li> <li>2) Respect <b>the dignity, reputation, rights and legitimate interests</b> of human beings</li> <li>3) Pay official taxation levied by law</li> <li>4) Defend his/her motherland and discharge military service according to law.</li> </ol>

Нэр төр, алдар хүндийг улс орнууд Үндсэн хууль, Иргэний хууль болон Эрүүгийн хуулиар хамгаалдаг. Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан бөгөөд сонирхогч этгээдийн шаардлагаар иргэний нэр төр, алдар хүндийг түүнийг нас барсны дараа хамгаалж болдог байна. Гэвч цахим орчин хөгжсөн одоогийн нийгмийн нөхцөл байдлаас үүдэн Иргэний хуулийн холбогдох зохицуулалт нь хүний нэр төр, алдар хүндийг бүрэн хамгаалж чадахгүй тул Эрүүгийн хуулиар хамгаалах шаардлага гарч ирдэг байна. Нэр төр, алдар хүндийг Эрүүгийн хуулиар хамгаалахдаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохистой төвшнөөс хэтрүүлэн хязгаарлах эрсдэл байдаг тул өмнөх хэсэгт заасан нарийн тодорхой байх зарчмыг улс орнууд хатуу баримтлах шаардлагатай юм.

Монгол Улсын хувьд олон нийтийн цахим сүлжээг ашиглан худал мэдээ, мэдээлэл тараах замаар бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр, алдар хүндэд халдахыг цахим гэмт хэрэг биш, Иргэний хуулиар зохицуулах боломжтой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь Эрүүгийн хуулиар зохицуулах ёстой гэж үзсээр уг асуудлыг нэг мөр болгож, тогтвортой хамгаалалтад авч чадаагүй байна. Энэ нь үзэл бодлоо чөлөө илэрхийлэх эрхийг зохих хэмжээнээс хэтрүүлэн хязгаарласан, түүнчлэн хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах хүрээ хязгаарыг өргөн тавьж, улс төрч, эрх мэдэлтэн, албан тушаалтнуудад тэдний эсрэг дуу хоолойгоо илэрхийлсэн этгээдийг дарамтлах боломжтой байгаагаас үүдэлтэй.

Төрийн байгууллага, улс төрд нөлөө бүхий этгээдүүд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн ерөнхий заалтыг ашиглан тэдгээрийн албаны үйл ажиллааг шүүмжилсэн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх, хорих ял оногдуулах нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээ, эрх зүйн зарчимд нийцэхгүй, хүний эрхийг зөрчдөг байна.

Төрийн байгууллага гэдэг хувийн аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн адил албаны нэр хүндтэй байдаггүй. Төр өөрөө хуулиар эрх мэдэл шилжүүлэн авч, үүрэг хүлээж байгаа мөртлөө хууль бус хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, аливаа шийдвэрээ олон нийтээр шүүмжлүүлэхгүйгээр ажил хэргийн нэр хүндээ хамгаалж буй үндэслэлээр хувь иргэний эсрэг гомдол гаргадаг байх нь зөвхөн дарангуйллын тогтолцоотой нийгэмд байх үзэгдэл.

Иймд нэр төр, алдар хүндийг хамгаалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эдлүүлэх тэнцвэртэй харилцааг бий болгох зорилгоор Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг тодорхой болгон хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

## **1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох**

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн хувьд сөргөөр нөлөөлөх байдлыг дараахь байдлаар тодорхойлж болно.

<b>Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг</b>		<b>Нөлөөлж буй хэлбэр</b>
1	Хохирогч	Хохирогч нь улс төрд нөлөө бүхий этгээд байх тохиолдолд албаны үйл ажиллагаагаа хуульд нийцсэн байдлаар явуулж байгаа эсэхэд эргэлзээ төрсөн, хардсан, сөрдсэнийг Эрүүгийн хуулиар хамгаалах боломжгүй болно. Харин улс төрд нөлөө бүхий этгээдийн хүн болж төрснийхээ хувьд өөрөөс нь салгахгүй эрхэм чанар болох нэр төрийг хязгаарлахгүй.

## **1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл**

Монгол Улс социалист дэглэмтэй байхад нэг намын удирдлага, хараа хяналт дор бүхий л хэвлэл мэдээлэл байсан бөгөөд намын үзэл суртлыг эсэргүйцсэн мэдээ, мэдээллийг дамжуулах хориотой байсан. Эрх барих байгууллагыг шүүмжилсэн хүн шийтгүүлдэг, дарамт шахалтад өртдөг, хэлмэгддэг байлаа. 1992 оны Үндсэн хуулиар “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”<sup>6</sup> гэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эдлүүлэхээр заасан. Харин нэр төр, алдар хүндийг хамгаалах үүднээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа дээр дурдсан зарчимд тулгуурлахгүй, хязгаарлалтын хүрээг хэтрүүлсэн байна. Тухайлбал, хүний нэр төр, алдар хүндэд халдсан худал мэдээлэл тараасан, гүтгэсэн, доромжилсон гэх

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэг



үйлдлүүдийг эрүүгийн хуулиар зохицуулж ирэхдээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зохистой төвшнээс үргэлж хэтрүүлж байжээ.

Хил хязгааргүй сэтгүүлчид (Reporters Without Borders) олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс нийт 180 орноос 2012 онд 100-р байр, 2015 онд 54-р байр, 2020 онд 73-р байранд тус тус оржээ. Сүүлийн жилүүдэд хэвлэлийн эрх чөлөөний индекс унасаар байгаа нь Эрүүгийн хуулийн хүнд санкци, төрийн байгууллагын сэтгүүлчдийн эсрэг гомдол гаргах эрхийн хүрээтэй холбоотой гэжээ.

## Хүснэгт 2



2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110 дугаар зүйлд доромжлох буюу “бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон” үйлдлийг, 111 дүгээр зүйлд гүтгэх буюу “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан” үйлдлийг зохицуулсан.

2017 оны 7 дугаар сараас хойш дээрх зохицуулалтыг зөрчилд тооцохоор болж, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “гүтгэх” зөрчил буюу хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан үйлдэлд хариуцлага тооцож эхэлсэн.

2020 оны 1 дүгээр сараас хойш 2015 оны Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхээр зохицуулж байна.


№	Эрүүгийн хууль (2002 он)	Зөрчлийн тухай хууль (2015 он)	Эрүүгийн хууль (2015 он)
	<p><b>110 дугаар зүйл.</b> <b>Доромжлох</b> 110.1. Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол <i>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</i>, эсхүл <u>нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</u></p> <p><b>111 дүгээр зүйл. Гүтгэх</b> 111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол <i>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</i>, эсхүл <u>нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</u></p> <p>111.2. Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол <i>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</i>, эсхүл <u>гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</u></p> <p>111.3. Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол <i>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</i>, эсхүл <u>хоёроос таван жил хүртэл</u></p>	<p><b>6.12 дугаар зүйл.</b> <b>Гүтгэх</b> 1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг <i>хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр</i>, хуулийн этгээдийг <i>хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр</i> торгоно.</p>	<p><b>13.14 дүгээр зүйл.</b> <b>Худал мэдээлэл тараах</b> 1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол <i>дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</i>, эсхүл <i>хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх</i>, эсхүл <i>нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</i></p>

	хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
--	--------------------------------	--

2002 оны Эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндийг гутаасан, доромжилсон, илт худал мэдээлэл тараасан, эдгээрээс хор уршиг учирсан тохиолдолд 8 сая 400 мянгаас 21 сая хүртэлх хэмжээний төгрөгөөр торгохоос гадна таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэх санцтай байжээ. Энэ нь иргэний хувьд, хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд үг хэлэхгүй байх хэмжээний хүнд ял шийтгэл юм.

2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтуудыг тоон үзүүлэлтээр харьцуулан шинжилж үзье.

**Зураг 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110, 111 дүгээр зүйлээр бүртгэгдсэн гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлт /2011-2016 он/**



Хүний нэр төр, алдар хүндэд халдсан үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуульд доромжлох гэмт хэрэг ба гүтгэх гэмт хэрэг гэж зохицуулж байсан. Дээрх тоон үзүүлэлтээс харвал 2011-2016 оны хооронд 2002 оны Эрүүгийн хуулийн “доромжлох” гэмт хэрэг нийтдээ 74 бүртгэгдсэн ба нэг жилд дунджаар 13 орчим гэмт хэрэг бүртгэгдэж байжээ. Харин гүтгэх гэмт хэрэг нь нийтдээ 144 бүртгэгдсэн ба нэг жилд дунджаар 29 хэрэг бүртгэгддэг байв. Ингээд доромжлох, гүтгэх гэмт хэрэг 5 жилийн хугацаанд нийт 218 бүртгэгдсэн бөгөөд жилд дунджаар 44 хэрэг бүртгэгддэг байжээ. Эдгээр бүртгэгдсэн хэргүүд эцэслэн шийдвэрлэгдэлгүй шүүхийн шийдвэр гарахгүйгээр дуусах хандлагатай байна. Учир нь улс төрд нөлөө бүхий этгээдүүд мэдээллийг устгахыг шаардах, сэтгүүлч болон хувь

<sup>7</sup> Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Статистикийн хэлтэс 2011-2016 онд Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд ЭХТА-ийн 110, 111 дүгээр зүйл ангиар бүртгэгдсэн гэмт хэрэг, түүний шийдвэрлэлтийн статистик, судлаачийн эмхэтгэсэнээр.

иргэнийг хүний эрх хөндөгдсөн асуудлыг хөндөж бичих, ярихыг хязгаарлахаар хүнд ял шийтгэлээр сүрдүүлдэг байна.

2015 оны Зөрчлийн тухай хуулийг мөрдөж эхэлснээс хойш хагас жил хүрэхгүй хугацаанд “гүтгэх” зөрчил 111 бүртгэгдсэн. Үүнээс 18 хувь нь шийтгэврээр торгож, 82 хувь нь хэрэгсэхгүй болсон. Хэргийн бүртгэгдсэн тоо огцом өссөн нь мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан гэх шинэ зохицуулалт орсонтой холбоотой байж болох ч тэдгээрийн дийлэнхи хувь хэрэгсэхгүй болсон нь эрх мэдэлтнүүдийн сүрдүүлэг, үзэл бодлоо илэрхийлэх орон зайг хумих гэсэн оролдлого ч мөн нэмэгдснийг илэрхийлж байна.

2015 Эрүүгийн хуульд нэмэгдэж, 2020 оны 1 сараас хэрэгжиж эхэлсэн 13.14 дүгээр зүйлд заасан илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн судалгаагаар<sup>8</sup> өнгөрсөн 8 сарын хугацаанд нийт 107 эрүүгийн хэрэг бүртгэгдсэний улс төрд нөлөө бүхий этгээдийн гомдлоор хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдуулан шалгагдсан хэргийн тоо 36 байна. Энэ бүх тоо нэр төр, алдар хүндийг хамгаалах эрүүгийн хуулийн заалт хэт ерөнхий бөгөөд эрх мэдэлтэн, улс төрчид уг гэмт хэргийн хохирогч болон гомдол гаргах боломжтой байгаагаас үүдэлтэй.

Уг зохицуулалтын дэвшилттэй тал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсний төлөө хорих ял оногдуулдаг байсныг халсан явдал юм. Гэвч тухайн заалтыг хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хүний алдар хүндийг хамгаалах үүднээс хязгаарлахад тавигддаг зарчимд нийцүүлэн хуульчлахгүй бол Монгол Улс хэвлэлийн эрх чөлөөний индексээр дэлхийд улам бүр хойшоо жагссаар дарангуйллын тогтолцооны хэв шинжтэй улс болох эрсдэл байсаар байна.

Төрийн шүүмжлүүлэх, хардуулах хүрээг жирийн иргэн хүнийхтэй ижил төвшинд зохицуулснаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боож, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэд Үндсэн хуулиар хамгаалуулсан мэдэх эрх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих эрхээ хэрэгжүүлж чадахгүй юм.

2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудаас олон нийтийн зүтгэлтэн, улс төрийн албан тушаалтнууд шүүмжийг энгийн иргэнээс илүү хүлцэн тэвчих талаар хаана ч тусгагдаагүй байна. Хүний эрхийн Европын шүүх энэ шаардлагын талаар ийнхүү тэмдэглэсэн:

*Хүлээн зөвшөөрч болох шүүмжийн хүрээ нь жирийн хувь хүнтэй харьцуулахад улс төрч, төрийн албан хаагчийн хувьд илүү өргөн байдаг. Жирийн хувь хүнээс ялгаатай нь, улс төрч нь сэтгүүлчид болон олон нийтээр өөрийн үг болон үйл хэрэг бүрийг нухацтай шүүн шалгуулахыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй бөгөөд анхнаасаа үүнийг мэдсэн байдаг тул их хэмжээгээр хүлцэн тэвчих ёстой.*<sup>9</sup>

<sup>8</sup> Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 8 сард бүртгэгдсэн Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн судалгаа 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

<sup>9</sup> *Lingens v. Austria*, 8 July 1986, Application No. 9815/82, para.

Иргэний журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлэхэд мөн л нэхэмжлэгч бус хариуцагч мэдээллийн үнэнг нотлох шаардлагатай тул үг хэлснийхээ төлөө, эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө хохирч, иргэдийн дуу хоолой болох сэтгүүлчид хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхээс цааргаладаг нөхцөл үүссэн байна. Гэвч иргэний журмаар нэр төр, алдар хүндээ хамгаалуулах эрх хэн бүхэнд боломжтой байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зохистой байдлаас хэтрүүлэн хязгаарлагдаж байгааг хязгаарлах, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах болон хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тэнцвэртэй байдлыг Эрүүгийн хуулиар нарийн тодорхойлох, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх, эрх чөлөөгөө иргэд бодитой эдлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

*Хүснэгт 4*

<b>Хувилбар</b>	<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>	<b>Үр дүн</b>	
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдсан асуудал арилахгүй үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч хуулийг нарийн тодорхой болгоогүйгээс төр, иргэн, хуулийн этгээдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр сөрөг үр дагавар ихсэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг хангах боломжгүй бөгөөд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, нэр төрөө хамгаалуулах эрхийг хуулиар хамгаалахад нөлөөлөх ч асуудлыг шийдвэрлэн	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүн сөрөг

		зорилгод хүрэх боломжгүй.		
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Төрөөс зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглах зохицуулалт хийх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төрөөс интервенци хийх шаардлагагүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Иргэний үндсэн эрхийг хуулиар л хамгаалах боломжтой учир захиргааны шийдвэр гарган хамгаалах боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг арилгахад нөлөөлж чадахгүй.	Үр дүн сөрөг
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	2015 оны Эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах зохицуулалтыг нарийвчлан боловсронгуй болгож, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боох боломжийг хязгаарлаж, эрхийн тэнцвэртэй үр ашигтай зохицуулалт бий болгох боломжтой.	Зардал гарахгүй бөгөөд асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

Аргачлалын 5.4.1-д тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно гэж заасан.

Асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж заасан хүний салшгүй эрхийг хөндөж байх тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно. Энэ тохиолдолд анхдагч хуулийн төсөл боловсруулахгүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах юм.

Эрүүгийн хуулиар иргэний Үндсэн хуулиар баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зохистой хязгаарлаагүй зохицуулалт үйлчилж байгаа нь ардчиллын үнэт зүйл, хүний эрхийг дээдлэх зарчмыг ноцтой зөрчих нөхцөл бий болгож байх тул Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

## **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

### **4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Эрүүгийн хуулийн заалтыг улс төрд нөлөө бүхий этгээдүүд ашиглан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зохистой хэмжээнээс хэтрүүлэн хязгаарлаж буй асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага байна.

Иймд улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн хүний хувьд тэгш эдлэх ёстой нэр төрийг хамгаалж, харин иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчдын эрхийг зөрчиж буй асуудлыг шийдвэрлэх тэнцвэртэй буюу зохистой эрх зүйн зохицуулалт бий болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй болно.

### **4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Нэмэлт зардал гарахгүй бөгөөд иргэнд эрхээ эдлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ. Улсын төсөвт ямар нэр нөлөө үзүүлэхгүй байна.

### **4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Иргэд олон нийтийн сүлжээнд хүний нэр төр, алдар хүндэд халдаж, хохирол учруулдагт хорих ял оногдуулахгүйгээр Эрүүгийн хуулиар зохицуулах нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх иргэдийн эрх зөрчигдөхгүйгээр нэр төр, алдар хүнд хамгаалагдах нөхцлийг бүрдүүлнэ.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчдаар дамжуулан эрхээ хэрэгжүүлдэг иргэдийн эрхийг хумих, төр өөрийн дарангуйллыг тогтоох үндэс суурийг бий болгохгүй байх ач холбогдолтой байна.

#### **4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Байгаль орчинд ямар нэгэн шууд ба шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин байгаль орчны асуудлыг хөндөгдөх, түүнтэй холбоотой иргэдийн эрх зөрчигдөх тохиолдолд үүнийг илэрхийлэн хамгаалах боломж хязгаарлагдахгүй байх эерэг нөлөөтэй байна.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...нэр төрийг нь доромжилж болохгүй”, Арван долдугаар зүйлийн 1.2 дахь заалтад “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” гэж заасантай нийцэж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүнийг хязгаарлах нөхцлийг заасан зарчимд тус тус нийцэж байх тул хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй байна.

### **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;



- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой байна.

## **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

### **6.1. Олон улсын пакт дахь зохицуулалт**

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17-р зүйлд ийнхүү заасан байдаг:

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл **нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.**
2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй. Хүний эрхтэй салшгүй холбоотой дээрх ойлголтуудыг хамгаалахын тулд зохих хэмжээнд бусдын эрхийг ч хязгаарлаж болох зохицуулалтыг мөн энэхүү пактад тусгасан байна:

#### **19 дүгээр зүйл**

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг **зарим талаар хязгаарлаж болох** боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:
  - a. **бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;**
  - b. үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.Тиймээс эдгээр эрхүүд хоорондоо зөрчилдөхөд тэнцвэртэй байлгахын тулд улс орон бүр хичээсээр иржээ.

### **6.2. Америкийн Нэгдсэн Улсын туршлага**

Америкийн Нэгдсэн Улс нь Үндсэн хуулийн шүүхийн үүргийг Дээд шүүх нь гүйцэтгэдэг улс бөгөөд доод шатны шүүхэд аливаа маргаанд иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан хэлэлцдэг билээ. Дээд шүүхийн шийдвэрүүд Үндсэн

хуульд заасан иргэний үндсэн эрхүүдийн томъёоллыг хэрхэн ойлгох, тайлбарлах талаар жишиг тогтооно. Түүнчлэн эрх зүйн хөгжилд онцлох хувь нэмэр оруулсан томоохон өөрчлөлт дагуулсан шийдвэрийг түүхэн шийдвэр /landmark decision/ гэж тодотгодог. Тийм шийдвэрийн нэгэн жишээ бол 1964 оны Нью Йорк Таймс компани болон Сулливаны хоорондох маргааны шийдвэр юм.

Нью Йорк Таймс сонин нь 1960 оны 3-р сарын 29-нд Мартин Лутер Кингийн тухай болон түүний оролцсон иргэний хөдөлгөөний эсрэг цагдаа нар хэрхэн зүй бус арга хэмжээ авсан тухай нэг нүүр төлбөртэй сурталчилгаа нийтэлжээ. Мартин Лутер кингийг хамгаалах хороо нийтлэлийг байрлуулсан ба цагдаагийн байгууллага, албан тушаалтнуудын үйлдлийг шүүмжилсэн нийтлэл байжээ. Тус нийтлэлд баримтын хувьд үнэн зөв гэхээргүй мэдээллүүд агуулсан байсан. Жишээлбэл, Мартин Лутер кингийг 7 удаа баривчилсан гэх боловч 4 удаа л баривчилсан, Алабама мужийн коллежийг маш олон цагдаа нар хүрээлэн бүсэлсэн гэх боловч сургуулийн байрыг тойроогүй, ойр орчимд байрласан гэх мэт нарийн ярьвал ташаа мэдээлэлтэй сурталчилгаа байжээ.

Жагсаал, хөдөлгөөн өрнөсөн Алабама мужийн Монтгомери хотын цагдаагийн дарга Л.Б.Сулливан нь түүний удирдах байгууллагын үйл ажиллагааг гүтгэснээр өөрийг нь гүтгэж байгаа гэсэн үг хэмээн мужийн хууль, журмын дагуу шүүхэд хандан Алабама мужийн шүүхэд хохирол барагдуулах 500,000 долларын нөхөн төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гаргуулсан. Тэрээр үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь гүтгэлгийн шинжтэй хэвлэн нийтлэлийг хамгаалахгүй гэж үзэв.

Нью Йорк Таймс энэ асуудлаар Дээд шүүхэд хандаж, амжилттайгаар заргаа авч чадсан байна. Нөхөн төлбөр гаргуулах шийдвэрийг хүчингүй болгож, Нью Йорк Таймс нь үндсэн эрхийнхээ хүрээнд хийсэн үйлдэлд хариуцлага гэж тогтоосон байдаг. Энэ шийдвэрээр анх удаа төрийн албан тушаалтан нь гүтгэх гэмт хэргийн хохирогч болохын тулд гэмт хэргийг үйлдсэн этгээд гэм буруугийн санаатай хэлбэртэй байх гэсэн шаардлагыг цохон тэмдэглэжээ. Түүнээс хойш, энэ шийдвэрийн жишгээр төрийн албан хаагч өөрийг нь гүтгэсэн бол шүүгдэгч тухайн мэдээлэл худал байсан ч хэвлэн нийтлэхдээ, үг хэлэхдээ худал байсан гэж мэдээгүй бол хариуцлага хүлээхгүй гэсэн зарчим бий болсон байна.

Жирийн иргэд хоорондын маргаанд үл хамаарах энэхүү тусгай нөхцөл нь зөвхөн хохирогч нь төрийн албан хаагч байгаа тохиолдолд үйлчилнэ. АНУ нь төрийн байгууллын онцлогоор муж тус бүр харилцан адилгүй хууль тогтоомжтой тул гүтгэх гэмт хэргийн хувьд мөн адил ялгаатай зохицуулсан байдаг. Гэхдээ “олны танил хүн” зарчим /public figure doctrine/ нь орон даяар ижилхэн үйлчилнэ. Дээд шүүх нь 1966 онд улс төрийн албан тушаалтнуудаас гадна олонд танигдсан урлаг, уран сайхны од болон бизнесийн хүмүүсийг мөн адил гүтгүүлсэн бол гүтгэсэн хүн нь худлаа гэдгийг мэдсээр байж санаатайгаар эсхүл илт болгоомжгүй хандсан гэдгийг нотолж байж гүтгэх гэмт хэргийг үйлдсэн болно.

Өөрөөр хэлбэл, олны танил хүний тухай худал мэдээлэл тараасан ч түүнийг худал гэж мэдэн санаатайгаар эсхүл мэдэх боломжтой байхад хайхрамжгүй хандан нийтлээгүй л бол мэдээлэл нь худал байсан ч гэмт хэрэг үйлдсэн болохгүй. Энэ ялгамжтай харилцааг зөвтгөж буй тайлбар нь олны танил,

нөлөө бүхий хүмүүст гүтгэгдлээ гэж заргалдаж, шүүхээр шийдүүлэхийн тулд илүү өндөр шалгуур тавих ёстой байдаг гэжээ. Мөн олны танил хүмүүст энгийн иргэнтэй харьцуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд илүү хүртээмжтэй байх тул гүтгэлгийн талаар залруулга хийх гэх мэт арга хэмжээ авах бололцоотой гэж үздэг байна.

### **6.3. Бусад хөгжингүй орнуудын туршлага**

Дээр дурдсанчлан, өдийг хүртэл олон орнууд гүтгэлгийг ямар нэгэн байдлаар гэмт хэрэг болгон хуульчилж, энэхүү харилцааг эрүүгийн эрх зүйгээр зохицуулж байгаа билээ. Гэвч хөгжингүй орнууд буюу эрх зүйн соёл, ухамсар нь тодорхой түвшинд гарсан тогтолцоонд АНУ-д хэрэглэдэг олны танил хүн зарчимтай төстэй онол, номлолыг ямар нэгэн байдлаар хэрэгжүүлдэг юм. Олны танил хүн гүтгэлгийн гэмт хэргийн хохирогч болохын тулд тухайн гэмт хэргийг үйлдсэн гэдгээс гадна санаатайгаар эсхүл илт болгоомжгүй үйлдсэн гэдгийг нотлох шаардлагатай байдаг. Иймд ийнхүү нотлох өндөр шалгуурыг хангахад бэрх тул энэ нь өөрөө хэвлэлийн эрх чөлөөний хамгаалалтын механизм болно. Хэрвээ худлаа мэдээллээр нэр хүндэд хандсан байвал санамсаргүй гаргасан алдаа л байхад олны танил хүн тэр зэргийн эрсдэл үүрэх нь зүй ёсны хэрэг гэж үздэг. Мөн тухайн мэдээлэл худлаа бол буруу, ташаа байсныг энгийн иргэнээс илүү залруулах боломж, бололцоотой гэсэн үзэл санаанд суурьтай.

### **6.4. Филиппин улсын туршлага**

Филиппин улс нь гүтгэх гэмт хэргийг хуульчилж зохицуулахдаа олны танил хүний зарчмыг үзэл баримтлал болгоогүй бөгөөд энэ асуудлаар НҮБ-ын Хүний эрхийн хороо удаа дараа байр сууриа илэрхийлж байжээ. Гүтгэлгийн гэмт хэрэг нь хорих ял эсхүл эсхүл торгох ял эсхүл хоёуланг нь иргэний шүүхээр хохирол барагдуулах хариуцлагын хамтаар хүлээлгэж болохоор зохицуулсан байдаг.

НҮБ-ын Хүний эрхийн хороо анх 2012 онд гүтгэлгийн хууль тогтоомж зөрчсөний төлөө хоригдсон сурвалжлагч гомдол гарган хандсанаар энэхүү эрх зүйн зохицуулалтыг хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөрчсөн, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гаргаж байжээ. 2012 оны дотор гэхэд Филиппиний дээд шүүхэд энэхүү хууль нь Үндсэн хууль зөрчсөн талаар 5 гомдол хүргүүлсэн. Гэтэл өнөөдрийг хүртэл энэхүү хууль нь цахим орчинд ч маш чанга мөрдөгдсөн хэвээр бөгөөд Хүний эрхийн хороо шүүмжилсээр байна. Хамгийн сүүлд гарсан томоохон хэргийг дурдвал 2020 оны сард болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлч Мариа Рийсагийн баривчилгаа юм. 2012 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу, энэ хуулийг зөрчсөн асуудлаар өмнөх хуулийн байгууллагын өндөр албан тушаалтны хууль бус үйлдлүүдийн тухай цахим нийтлэлийг нь гүтгэсэн гэж үзэж ялласан байна.

Филиппин улсын зохицуулалтаар олон нийтийн танил хүн хохирогч болж, хэрэг үүсгэхэд хэцүү болгодоггүй төдийгүй хуульд заасан тодорхой нөхцөл хангасан эсхүл сайн санаа буюу үндэслэл бүхий зорилго нотлогдохгүй тохиолдолд бүх гүтгэлэг бүхий нийтлэлийг гэм буруугийн хэлбэрийн хувьд санаатай гэж үзэхээр хуульд заасан байдаг. 2020 онд Мариа Рийсад оноосон ялыг олон улсын эх сурвалжууд болон НҮБ-ын Хүний эрхийн хороо мөн л буруутгасан.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, 6 дахь хэсгийн “Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Улс төрд нөлөө бүхий этгээдийн гомдол гаргах эрхийг нарийн тодорхой заах буюу улс төрд нөлөө бүхий этгээд нэр төрөө хамгаалах боломжийг бүрдүүлж, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд халдах боломжийг хязгаарлах зохистой зохицуулалтыг бий болгох;
2. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эдлэх бодит нөхцлийг бий болгох зорилгоор Эрүүгийн хуулиар иргэд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагийн ажилтныг хорих ялаар шийтгэх эрх зүйн зохицуулалт бий болгохгүй байх;
3. Улс төрд нөлөө бүхий этгээдийн гомдол гаргах эрхийг хязгаарлахдаа тухайн хүний эрхэм чанарыг хамгаалж, нэр төрд халдсан тохиолдолд тухайн гэмт хэргийн хохирогч байж болохоор тэнцвэртэй зохицуулалтыг хуульчлах шаардлагатай гэж үзлээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн олон улсын зарчимд нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

## ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 1

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
<b>1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх</b>	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Энэхүү хуулийн төсөл нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэх зохицуулалт шинээр бий болгоогүй ч олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа болно.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Эрүүгийн хуулийн зохицуулалт олонхи, цөөнх гэж ялгахгүй тэгш үйлчилнэ.

	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь иргэдийн үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж байгаа тул эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй иргэд байхгүй байна.
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө хамгаалагдаж, ардчилсан Үндсэн хуулийн зарчим хангагдах нөхцөл бүрдэх учир хүний эрхийг хамгаалах хүрээнд томоохон ахиц дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын к11 дүгээр зүйлийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвлөмжид бүрэн нийцэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хуульд заасан холбогдох гэмт хэргийн санкцийг хорих ял болгохгүй тул хүний эрхийг хамгаалж байгаа.
<b>2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх</b>	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, хууль ёсны зарчмыг бэхжүүлэх зорилготой байна. Иймд төрийн байгууллага, улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн Эрүүгийн хуулийн заалтыг ашиглах иргэдийнхээ эрх, эрх чөлөөнд халдах боломжийг хязгаарлаж

				байна. Энэ нь хоёр эрхийн тэнцвэртэй буюу хууль ёсны байх зорилгод нийцсэн.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн байгууллагын хуулиар зөвтгөхгүй хүний эрхийн хязгаарлалтыг авч хаях зорилгоор тэдгээрийн иргэний хувьд нэр төрөө хамгаалах эрхийг хамгаалахаас бусад тохиолдолд холбогдох гэмт хэргийн хохирогчид хамаарахгүй байхаар зохицуулах зайлшгүй шаардлагатай байна. Учир нь уг хязгаарлалтгүйгээр хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах боломжгүй.
<b>3. Эрх агуулагч</b>	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Монгол Улсын иргэн, төрийн байгууллага, улс төрд нөлөө бүхий этгээд эрх агуулагчид хамаарна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Дээр дурдсан этгээдүүд эмзэг байдалтай гэж тодорхойлолтод хамаарахгүй байна.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Дээрх үндэслэлээр
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Дээрх үндэслэлээр

Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчид нь мөн адил үүрэг хүлээгчдэд хамаарна.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

### Хавсралт 2

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал		2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй



	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

	төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх			
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

### Хавсралт 3

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун ёс	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагад ямар нэг үүрэг хүлээлгээгүй, үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөхгүй. Хүний эрх зөрчих нөхцлийг хязгаарлаж байгаа.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэгээр нөлөөлөх болно. Иргэний журмаар нэр төр, алдар хүндээ хамгаалуулахад шууд бусаар эерэг нөлөө үзүүлж байна.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нэр төр, алдар хүндэд халдсан бодитой тохиолдлыг нээж илрүүлэх нөхцөл бүрдэнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 4

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх			
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй